


Ирээд, Намайг дага ҮЙЛ АЖИЛЛАГАА

Гэр бүлийн үдэш, судраас судлах зэрэг зугаатай үйл ажиллагаанд зориулав!



8-р сарын 26-аас 9-р сарын 1

Бат бөх суурь

ХИЛАМАН 1-6

Хиламан хөвгүүддээ амьдралаа Есүс Христийн бат бөх суурь дээр барихыг заав (Хиламан 5:12-ыг үзнэ үү). Аливааг дээр нь барьдаг зүйл бол суурь юм. Бат бөх суурь бол барилгыг бүхэлд нь шуургангаар ч бат бөх байлгадаг зүйл. Бат бөх суурьтай, сул суурьтай хоёр цамхаг барь. Аль цамхаг нь илүү тогтвортой вэ? Бид амьдралаа хэрхэн Есүс Христ дээр суурилуулж болох вэ?

Бага насны хүүхдүүдэд: Бага насны хүүхдүүддээ тэдний үнэхээр их хүчтэй гэж боддог зүйлийг олоход тусал. Тэд юу олсон бэ? Бид Есүс Христтэй хамт хүчтэй байж чадна гэдгийг заа.



9-р сарын 2-8

Христийн талаарх гэрчлэл

ХИЛАМАН 7-12

Судар дээрх олон хүн Есүс Христийн тухай зааж, гэрчилсэн (Хиламан 8:16-20-ийг үзнэ үү). Чи ч мөн Түүний талаарх гэрчлэлээ хөгжүүлж эхэлж чадна! Гэрчлэл нь Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрын талаар үнэн гэж мэддэг буюу итгэдэг зүйл юм. Гэрчлэлээ бичиж аваад гэр бүл, найзуудтайгаа хуваалцах дадлага хийгээрэй.

Бага насны хүүхдүүдэд: Бага насны хүүхдүүддээ Есүс Христийн юунд нь дуртайг асуу. Тэгээд Аврагчийн талаарх гэрчлэлээ тэдэнд хуваалц.



9-р сарын 9-15

Хэрэм рүү авирч буй Самуел

ХИЛАМАН 13-16

Самуел Есүс Христийн тухай хүмүүст хотын хэрмэн дээрээс заасан бошиглогч юм (Хиламан 13:4-ийг үзнэ үү). 12-р хуудас руу очоод, Самуелын түүхийг ярихад чамд туслах гар урлалыг хий.

Бага насны хүүхдүүдэд:

Бага насны хүүхдүүдээ сандал дээр зогсож байхад нь бариад Есүс Христийн тухай мэддэг зүйлийг нь Самуелын адил хуваалцаарай.



9-р сарын 16-22

Цугларах тоглоом

3 НИФАЙ 1-7

Есүс Христ хүн бүрд хайртай, тэднийг сайн мэдээг хүлээн аваасай гэж хүсдэг учир Тэрээр бүх хүүхдээ цуглуулах болно гэж амласан (3 Нифай 5:24-ийг үзнэ үү) Цугларах тухай тоглоом тогло. Тоглогчдыг тойрог болгон зогсоо. Тойргийн голд байгаа нэг хүн дуртай өнгө зэрэг өөрийнхөө тухай нэг баримт хэлнэ. Хэрэв энэ баримт хэн нэгний хувьд үнэн байвал гол руу очно. Бүх хүн голд цугларах хүртэл үргэлжлүүлээрэй.

Бага насны хүүхдүүдэд зориулав:

Бяцхан үрстэйгээ нуугдаж тоглоорой. Тэд таныг олох үед тэднийг чангаар тэвэрнэ үү. Бидний хаана байхаас үл хамааран Есүс Христ биднийг хэрхэн цуглуулна гэсэн амлалтынх нь талаар ярилцаарай.



9-р сарын 23-29

Есүс бол Гэрэл

3 НИФАЙ 8-11

Есүс Христ бол "дэлхийн гэрэл ба амь" (3 Нифай 9:18). Гэр бүлийнхэнтэйгээ хамт нар мандахыг эсвэл нар жаргахыг хараарай. Дараа нь харсан зүйлээ зур. Зурж байхдаа Есүс Христийг хайрладаг шалтгаануудаа мөн Тэрээр хэрхэн чамд гэрэл авчирдаг тухай ярилцаарай.

Бага насны хүүхдүүдэд зориулав:

Гадаа гараад нар, сар, одод шиг өөр өөр гэрлийг хар. Бяцхан үрсээсээ гэрэл тэдэнд ямар сэтгэгдэл төрүүлж буйг асуу. Есүс Христ хэрхэн бидний гэрэл байдаг талаар ярилц.